

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Албан шаардлага биелүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/539 дүгээр захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Ерөнхий хянан шалгагчийн 2025 оны 05 сарын 09-ний өдрийн 01/38 дугаар албан шаардлагын дагуу Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд заасан гурван талт гэрээний хувийг бүртгэлийн байгууллагад хүргүүлж урьдчилсан тэмдэглэгээ хийх үйл ажиллагааг холбогдох журамд заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Орон сууцны дэд бүтцийн хэлтэс (Г.Ганхүү)-д, гэрээ хариуцсан мэргэжилтэн нарт тус тус үүрэг болгосугай.
2. Дээрх урьдчилсан тэмдэглэгээ хийх үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд улирал тутам хяналт тавьж тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баялагт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БОЛОРТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯЛАГ